



**ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН СУРГАЛТ-ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ ЦОГЦОЛБОРЫН
2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төлөвлөгөөг хянасан:
ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН, СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН
ТУСГАЙ ЦОГЦОЛБОРЫН ДАРГА

(албан тушаал)

Төлөвлөгөөг хянасан:
ДОТООД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Боловсруулсан:
ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН
(албан тушаал)



Төсвийн Шууд захирагч

/С.АМГАЛАН /

/Н.ОДЦЭЦЭГ /

(огноо)

/Б.Болормаа /
(гарын үсэг)

/Б.БОЛОРМАА /

/..... /
(огноо)

НЭГ. ЗОРИЛГО

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд-залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын /цаашид цогцолбор гэх/ үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөөнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас нийгмийн асрамж, халамж, хүүхэд-залуучуудын хөгжил, хамгааллын асуудлаар шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангахад чиглэгдсэн бодлогын түвшний зохицуулалт түүний хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөх, бусад байгууллагатай харилцах, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах асуудлыг бүхэлд нь хамарсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын хэтийн чиглэлийг тодорхойлов.

ХОЁР. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, АГУУЛГА

Стратеги төлөвлөгөө нь дараах бүтэц, агуулгын хүрээнд боловсруулагдсан байна.

Үүнд:

1. Нийтлэг үндэслэл
2. Мандатын шинжилгээ
3. Алсын хараа
4. Эрхэм зорилго
5. Орчны шинжилгээ
6. Стратегийн зорилго
7. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги
8. Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, зураглал

ГУРАВ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Стратегийн төлөвлөгөөг боловсруулахад Засгийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийгмийг хөгжүүлэх 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, НЗДТГ болон холбогдох дээд байгууллагын удирдлага, үйл ажиллагаа /бизнес/-ны төлөвлөлт, байгууллагын бүтэц зэрэг нийгмийн салбарын харилцан хамаарлын арга зүйн хүрээнд боловсруулсан болно.

ДӨРӨВ. МАНДАТ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		22
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	16
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	16
Нэг. ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫГ СУРЧ БОЛОВСРОХ, АМЬДРАХ УХААНЫ ЧАДВАР ОЛГОХ, УРЛАГ СПОРТ, ЗРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ		
Үндсэн чиг үүрэг		Дэд чиг үүрэг
Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид		
1.Хүүхдийг сурч боловсрох нөхцлийг бүрдүүлэх.	Ерөнхий боловсролын сургуулийн боловсрол тасралтгүй эзэмшүүлэх хоцрогдлыг арилгах	БЗД-ийн ерөнхий боловсролын хэлтэс хамран хэрэгжүүлэх
2. Залуучуудыг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулан бие даан амьдрах дадал хэвшлийг би болгох	Сургалтаар дамжуулан ажил мэргэжлийн дадал зуршилд суралцсан байна.	Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтрах
3.Хүүхэд залуучуудын урлаг спортын хөгжлийг дэмжих	Хүүхэд залуучуудын сонирхлын дагуу секц дугуйланд хамруулах.	Цогцолбороос гадуурх дугуйлан секцэнд хамруулах.
Хамгаалалт шаардлагатай хүүхэд залуучуудыг шинээр бүртгэн бичиг баримтжуулан хүлээн авч хамгаалал болон хөгжлийн үйлчилгээнд хамруулан нийгэмшүүлэх	Хүүхэд залуучуудыг Сэтгэл зүйн болон болон аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үйлчилгээнд тогтмол хяналт тавих, соён гэгээрүүлэх олон талт үйл ажиллагааг чанартай зохион байгуулах.	Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын захирамжаар хүүхэд залуучуудыг хүлээн авах, Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.
ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГА, ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ХҮРЭЭНД		
Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх мэдлэг чадвар дээшлүүлэх, байгууллагын хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах	Багш нийгмийн ажилтан албан хаагчдыг чадвар дээшлүүлэх мэргэжлийн сургалтанд хамруулан чадавхжуулах. Албан байгууллагын нийт албан хаагчдыг ёс зүйн дүрмийг баримтлуулах	Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтрах
Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн	Нэгжүүдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөний дагуу шалгалтуудыг хийж даргын зөвлөлийн хурлаар	Нийслэлийн Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс

хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж ажлыг үр дүнтэй болгох үнэлэх	оруулан танилцуулсан ба шалгалтын дүгнэлт нь тухайн албан хаагчийн хагас болон бүтэн жилийн ажлыг дүгнэх	
Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалт болон зарцуулалтын мэдээг шилэн дансаар ил тод байлгах.	Төсвийн сахилга хариуцлагыг сайжруулан өр, авлага үүсгэхгүй ажиллах, Шилэн дансны программд сар, улирал, жилийн эцсийн байдлаар нийт мэдээг оруулж ажиллах	Нийслэлийн Санхүү төрийн сангийн хэлтэс
ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫГ ХАМГААЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД		
Хүүхэд залуучуудын эрхийг хамгаалах холбогдох хуулийн хүрээнд олон талт үйл ажиллагааг зохион байгуулан хууль эрх зүйн хамгааллын үйлчилгээг үзүүлэх.	Хүүхэд залуучуудыг гэмт хэрэг болон аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон эрсдэлд өртсөн хүүхэд залуучуудад хуулийн зөвлөгөөг өгөн хамгаалах үйлчилгээг үзүүлэх .	Төрийн болон төрийн бус байгууллага болон хуулийн зүйн салбаруудтай хамтран ажиллах.

ТАВ. АЛСЫН ХАРАА

Нийгмийн эмзэг бүлгийн эцэг, эхийн хараа хяналтаас гарсан, орон гэргүй, өнчин, хүнд нөхцөлд амьдарч байгаа төрөөс зайлшгүй анхаарал шаардсан хүүхэд-залуучуудыг халамж, асрамжийн үйлчилгээнд хамруулж, төлөвшүүлэн цаашид бие даан амьдрах чадварыг эзэмшүүлэх зорилгоор залуучуудын төвийн мэргэжлийн сургалтыг зохион байгуулан мэргэжил эзэмшүүлж, бие хүн болгон төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

Нийгмийн халамж, асрамжийн Гэр бүлийн хувилбарт үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхэд-залуучуудын бэлэнчлэх сэтгэлгээг өөрчлөх хөдөлмөрийн хүмүүжил олгон ар гэрт нь эргүүлэн нэгтгэх, мэргэжил эзэмшсэн залуучуудыг байнгын ажлын байраар ханган бие даасан амьдралын анхны гарааг нь зөв эхлүүлнэ. Үүний тулд эмзэг бүлэгт хандах нийгмийн сэтгэл зүйн таатай уур амьсгал бүрдүүлэх өрх гэр, иргэнд асуудлаа бие даан шийдвэрлэхэд нь зөвлөн туслах, нийгэм хамт олныг идэвхжүүлэх үүрэг зорилго бүхий нийгмийн ажлыг хөгжүүлэх сайн дурынхныг татан оролцуулах замаар гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагууд, хувь хүмүүстэй хамтран хэрэгжүүлнэ.

ЗУРГАА. ЦОГЦОЛБОРЫН ЭРХЭМ ЗОРИЛГО:

Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нийгмийн хамгааллын талаарх төрийн бодлого, нийгмийн эмзэг бүлгийн хүүхэд-залуучуудыг нийгэмшүүлэх,

мэргэжлийн чиг баримжаа олгон амьдрах арга ухаанд сургах, тэдгээрийг бие хүн болгон хүмүүжүүлэн нийгэмд идэвхтэй байр суурь эзлэхэд нь дэмжин тусалж нөлөөлөн ажиллах

ДОЛОО. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Дотоод орчин	
<p>Давуу тал</p> <ul style="list-style-type: none"> • Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хууль тогтоол, дүрэм, журам гэх мэт , эрх зүйн орчин бүрдсэн • Захиргааны алба, Үндсэн үйлчилгээний алба, Аж ахуйн алба гэсэн нэгжүүдтэй • -Мэдээлэл авах интернэт, веб сайт, хяналтын камерууд, радио узель үүрэн телефон холбоотой • -Мэргэшсэн ажиллах хүний нөөцтэй • -Ажлын байр , тоног төхөөрөмжөөр хангагдсан • Үйл ажиллагааны тогтмол санхүүжилттэй 	<p>Сул тал</p> <ul style="list-style-type: none"> • Нийгмийн халамжийн тухай хуулинд халамжийн төвүүдэд амьдарч байгаа хүүхэд залуучуудын их дээд сургуулийн төлбөр, нийтийн тээврээр зорчих асуудал орхигдсон • Цаг үеийн асуудлаар арга хэмжээ зохион байгуулах зардал төсөвт суутгагдаагүй • Цогцолборын ажилтнуудыг гадаад дотоодын мэргэшүүлэх сургалтад хамруулах боломж хязгаарлагдмал • Цогцолборын үйл ажиллагааны санхүүжилт зах зээлийн үнийн өсөлттэй уялдаж чаддаггүй • Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх боломж дутмаг • Мэргэжлийн сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх, хүний нөөц, санхүүгийн эх үүсвэр дутмаг
Гадаад орчин	
<p>Боломж</p> <ul style="list-style-type: none"> • Холбогдох байгууллагад шийдвэрлүүлэх асуудлаар хандаж санал тавих • Халамж асрамжийн үйл ажиллагаа явуулдаг Олон улсын болон ТТБ-тай хамтран ажиллах 	<p>Эрсдэл</p> <ul style="list-style-type: none"> • Хүүхэд залуучууд бэлэнчлэх сэтгэлгээтэй болсон • Ажлын байрны олдоц муу • Гадаадаас бэлэн мөнгөний /валют/ хандив, туслалцаа авах боломжгүй • Эрх зүйн орчин хязгаарлагдмал\ • Хүүхэд залуучуудад үзүүлэх мэргэжлийн сэтгэл заслын үйлчилгээ дутмагаас зарим хүүхэд, залуучуудыг хорт зуршлаас татгалзах, сэтгэл зүйн байдлыг бүрэн засах үйлчилгээг үзүүлж чадахгүй байгаагаас гарах хариу үйлдэл


НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Цогцолборын үйл ажиллагааны стратегийн зорилт, бүтцийн ерөнхий тогтолцооны хэрэгжилтийн үр дүн дараах үзүүлэлтүүдээр илэрхийлэгдэнэ. Үүнд:

- Төрийн үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгож ажилтнуудын ур чадвар мэдлэг, мэргэшлийг үе шаттайгаар дээшлүүлэн бүтээлч хамт олныг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, чанарыг сайжруулах, зардлын төсөв, санхүүгийн эх үүсвэр, зарлага санхүүжилтийг зүй зохистой зарцуулах
- Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийгмийг хөгжүүлэх 2021-2025 оны үндсэн чиглэлийн зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэн хүүхэд залуучуудын хөгжлийн үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлэх
- Хүүхдийн эрхийн, Хүүхдийн хамгааллын тухай болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиуд болон нийгмийн халамжийн тухай багц хуулийн хүрээнд халамж, хөгжил хамгааллын оновчтой бодлогыг хэрэгжүүлж төрийн үйлчилгээг хүүхэд залуучуудад түргэн шуурхай хүргэх.

Цогцолборын үйл ажиллагаа нь нийслэлийн зүгээс дэвшүүлсэн нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө, мэдээллийг тухай бүрд нь мэргэжлийн өндөр түвшинд өгч, гаргасан шийдвэрийг идэвх санаачилгатай биелүүлэхэд оршино.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН
СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ ЦОГЦОЛБОРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



**ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ ЦОГЦОЛБОР
БАЙГУУЛЛАГЫН 2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
НЭГ. ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ АЖИЛТНУУДЫН УР ЧАДВАР МЭДЛЭГ, МЭРГЭШЛИЙГ ҮЕ ШАТТАЙГААР ДЭЭШЛҮҮЛЭН БҮТЭЭЛЧ ХАМТ ОЛНЫГ БҮРДҮҮЛЭХ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ИРГЭДЭД ХӨНГӨН ШУУРХАЙ ХҮРГЭХ, ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ, ЗАРДЛЫН ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР, ЗАРЛАГА САНХҮҮЖИЛТИЙГ ЗҮЙ ЗОХИСТОЙ ЗАРЦУУЛАХ					
1. Багшийг хөгжүүлж, ур чадварыг нь сайжруулах “Чанартай багш-Чанартай боловсрол” төслийг хэрэгжүүлж, мэргэжлийн багшийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ /НЗД бөгөөд УБ хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.3.1/	1.1 Албан хаагчдыг мэргэжлийн мэргэшүүлэх багц сургалтад хамруулна.	ТАХ-ын мэдлэг чадвар сайжирч, ажлын бүтээмж 15%-аар дээшилсэн байна.	ТАХ-ыг мэргэшүүлэх сургалтын 2020 оны төлөвлөгөө 85% биелсэн	ТАХ-ыг мэргэшүүлэх сургалтын 2021 оны төлөвлөгөө болон ТАХ-ын нийгмийн баталгааг хангах 2021 оны төлөвлөгөө 100% биелсэн байна	
Мэргэшсэн чадварлаг, иргэндээ үйлчилдэг, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ. /Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 5.3.2/	2.1 Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчдын ёс зүйн зерчлийн мэдээг цахим хуудсаар ил тод мэдээлнэ.	ТАХ нь төрийн үйлчилгээний ёс зүйн дүрмийг мөрдөж алдаа дутагдалгүй ажилласан байх	Шударга ёс, ил тод байдал сайжирч, мэдээллийг хамт олонд хүргэсэн байна	ТАХ нь төрийн үйлчилгээний ёс зүйн дүрмийг мөрдөж алдаа дутагдалыг тухай бүрд засаж залруулан алдаа дутагдалгүй байж ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	
	2.2 Хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллага болон хуулийн этгээд тусгайлан	-Тухайн ажлын байранд тавигдаж байгаа шаардлагуудыг хангасан хүнийг ил	Тухайн ажлын байранд тавигдаж байгаа шаардлагуудыг хангасан 29 хүнийг	-Томилох, дэвшүүлэх ажлыг ил тод, шударга зарчмыг баримтлан хэрэгжүүлсэн байна.	

	бэлтгэгдэж, мэргэшсэн хүний нөөцтэй байна.	тод, шударга зарчмыг баримтлан томилсон мөн дэвшүүлсэн эсэх, - Мэргэжлийн албан хаагч сонгон шалгаруулсан байх.	ил тод, шударга зарчмыг баримтлан томилсон байна	- Мэргэжлийн албан хаагчдыг шалгаруулан томилсон байх.	
	2.3 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын стратеги төлөвлөгөө, ТАХ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн үр дүнг /KPI/ тооцох, албан хаагчдын сургалтын цахим систем /ERP-ийн дэд систем/ дэх мэдээллийн санг ашиглаж хүний нөөцийн чадавхийг хөгжүүлнэ	Байгууллагын стратегийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тухайн албан хаагчийн оруулсан хувь нэмрийг “Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт” /KPI/-ээр үнэлсэн байх.	Ажилтан бүрийн ажлыг улирлаар дүгнэхэд хэрэглэж байгаа бөгөөд дүгнэх ажил шударга, ил тод болсон ба багш, ажилчдын жилийн ажлыг нь дүгнэж, давхардсан тоогоор ур чадварын нэмэгдэл 10-25 хувийг 176 ажиллагсдад, үр дүнгийн урамшуулал 5-15 хувийг 180 багш, албан хаагчдад тус тус олгосон байна	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт болон байгууллагын онцлогт тохирсон нэмэлт үзүүлэлтүүдийг хэрэглэж хэвшсэн байна.	
3. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлж, иргэдийн оролцоог хангасан, авлигаас ангид, үр нөлөөтэй, хариуцлагатай, мэргэшсэн тогтвортой засаглалыг төлөвшүүлнэ.	3.1 Иргэдээс албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулна.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон холбогдох журмуудыг мөрдөн ажиллаж ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн	Нийт 95 өргөдөл ирснээс 90-г бүрэн шийдвэрлэж, 5 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна.	Өргөдөл, гомдлыг бүрэн шийдвэрлэж зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна	

/Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 5. /	3.2 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг хуваарийн дагуу тогтмолжуулж, үр дүнг тооцон, иргэдээс тусгасан санал, хүсэлтийг үйл ажиллагаандаа тусган ажиллана.	хугацаанд бүрэн шийдвэрлэсэн эсэх НЗД-ын 2018 оны А/1212 тоот захирамжийг мөрдөн бүх уулзалтуудыг гэрэл зураг, тэмдэглэл болон кейс файлаар баримтжуулан хадгалсан байх	Уулзалтуудаас гарсан санал, шийдвэрүүдийг байгууллагын дотоод нөөц боломжинд үндэслэн 100% биелүүлсэн	Уулзалтуудаас гарсан санал, шийдвэрүүдийг биелүүлсэн байна.	
4.Ковид цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээ хэрэгжүүлэх, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, нутгийн захиргааны байгууллагуудын салбар хоорондын харилцан ажиллагааг зохион байгуулах, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангаж, эдийн засаг нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлнэ. /НЗД бөгөөд УБ хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 1.1	4.1 Дээд газраас ирсэн захирамж болон тогтоолын хэрэгжилтийг хурдан шуурхай хангаж ажиллах.	-Дээд газраас ирсэн захирамж болон тогтоолын хэрэгжилтийг хурдан шуурхай хангаж ажиллах. - Гамшиг, Ковид-19 цар тахлаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан дагаж мөрдөн 18%-аар ахисан байх	Гамшиг, Ковид-19 цар тахлаас хамгаалах төлөвлөгөөний биелэлт 82%-биелэлсэн байна.	Дээд газраас ирсэн захирамж болон тогтоолын хэрэгжилтийг хурдан шуурхай хангаж ажилласан байна. Гамшиг Ковид-19 цар тахлаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан дагаж мөрдөн бүх албан хаагчдыг 100% шинжилгээнд хамруулсан ажилласан байна.	
5.Нийслэлийн ногоон байгууламжийг сайжруулах оновчтой менежментийг хэрэгжүүлэн, хотыг цэцэрлэгжүүлэх, ойжуулах, тохижилт бүхий гудамж, талбайг бий болгож, иргэдийн ая	5.1 Цогцолбор болон зуслангийн гадна, дотор орчинд ногоон байгууламжийг бий болгоно.	Хүүхдүүдийн байгаль, эх дэлхийгээ хайрлах үзэл төлөвшиж “Эко клуб”-ын ажилд 30%-ын чанарын ахиц гарсан байна.	Эко клуб нь 90 гаруй тасалгааны цэцгийг арчилж ургуулж, Зуслангийн ногооны талбайгаас 5 тн төмс мөн 80 орчим кг өргөст	Экологийн сургалт батлагдсан хөтөлбөр төлөвлөгөөний дагуу явагдаж, ногоон байгууламжинд нэмж мод тарих, мандлын болон тасалгааны цэцгийн төрөл болон	

<p>тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. /НЗД бөгөөд УБ хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 5.1/</p>			<p>хэмх, улаан лооль хурааж авсан байна. /71,4%/</p>	<p>тоог нэмж арчлан ургуулах, Од зуслангийн тариалалтаас 8 тн төмс, 5-аас дээш төрлийн хүлэмжний ногоог хурааж авч хүүхэд, залуусын хүнсэнд хэрэглэсэн байна</p>	
<p>6Иргэд олон нийтэд биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, амарч зугаалах тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор стандартад нийцсэн спорт, хүүхдийн тоглоомын талбайг байгуулна.</p>	<p>6.1 Хүүхдийн чөлөөт цагийг өнгөрүүлэх тав тухтай орчинг бүрдүүлэх, стандартад нийцсэн тоглоомын талбайг байгуулах.</p>	<p>4-9 насны хүүхэд тоглох стандартын дагуу тохижуулах.</p>	<p>Зуслангийн болон байгууллага дээрх тоглоомнууд, хөлбөмбөгийн талбайн аюулгүй байдлыг хангаж гагнаж сэлбэсэн.</p>	<p>Бага насны хүүхдийн чөлөөт цагаа өнгөрөөх стандартын дагуу аюулгүй хүүхдийн тоглоомын талбайг бий болгосон байна.</p>	
<p>нэмэгдүүлж, амарч зугаалах тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор стандартад нийцсэн спорт, хүүхдийн тоглоомын талбайг байгуулна. /НЗД бөгөөд УБ хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 5.1/</p>	<p>6.2 Хүүхдийн зуслангийн стандартын хэрэгжилтэнд хяналт тавьж, аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.</p>	<p>Монгол улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийтээр үйлчлэх хоол үйлдвэрлэл үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал MNS CAC/RCP 39 : 2011, ХНХ-ын сайдын 2017 оны А/74 тушаалаар батлагдсан "Сэтгэл зүйн зөвөлгөө, үйлчилгээ үзүүлэх журам", Хүүхдийн тоглоомын талбай MNS</p>	<p>Гал тогоо болон тоглоомны талбайтай холбоотой ямар нэгэн асуудал гараагүй ба гэмтэж бэртсэн хүүхэд залуус байхгүй байна</p>	<p>Хүүхдийн сэтгэл санаа болон аюулгүй байдлын 100% ханган тоглоомнуудыг байнга шалгаж, шаардлагатай тохиолдолд засаж сэлбэсэн байна,</p>	

		6751:2019 зэрэг стандартууд, журмуудыг мөрдөж хүүхдүүдийг осол гэмтэлгүй, халдварт өвчин гаргахгүй ажилласан байх.			
7.Ариутгал халдваргүйтэл хийх бодисын нөөц бүрдүүлэх, нийтийн эзэмшлийн гудамж, зай ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, халдваргүйжилтэд хяналт тавина. /НЗД бөгөөд УБ хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр /1.1.1.4	7.1 Цогцолборын гадна болон дотор очинд ариутгал халдваргүйжилтыг хийж цар тахлын халдвараас сэргийлэх	Албан хаагч болон хүүхэд залуучуудыг цар тахал өвчнөөс урьдчилан сэргийлэн тогтмол ариутгал цэвэрлэгээ хийж цар тахал өвчлөл гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллана.	100%	Цогцолборын албан хаагч болон хүүхэд залуучуудыг цар тахлаас урьдчилан сэргийлэн ариун цэвэр халдваргүйжилт тогтмол хийсэн байна.	
8.Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, хүүхдийг эрүүл баталгааг хоол хүнсээр хангана. /НЗД бөгөөд УБ хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.3.5/	8.1 Хоол хүнсний аюулгүй байдал, амч чанарт хяналт тавих	-Хүнсний хангамж тогтвортой, тэнцвэртэй байлгах . -Хүнс шим тэжээллэг чанартай байлгах -Хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал хангагдсан байх. Хоолны амт чанарыг сэтгэл ханамжийн судалгаагаар дүгнэх	Хоолны амт чанар, шим тэжээлийн чанарын талаар Сэтгэл ханамжийн судалгаар 96%	Хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжих, зайлшгүй шаардлагатай илчлэг, шим тэжээлийн шаардлага хангасан, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хүнсний бүтээгдэхүүн бэлдэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажилласан байна.	

<p>9Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийг хөгжилд чиглүүлсэн үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулсан байна. Төсвийн тухай Монгол улсын хуулийн 6.1 заалт\</p>	<p>9.1 Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах</p>	<p>Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу санхүүгийн сахилга батыг мөрдөж төсвийн сахилга хариуцлагыг сайжруулан өр, авлага үүсгэхгүй ажиллах ,</p>	<p>Төсвийн хэмнэлт 164 сая ₮, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаа Зөрчилгүй өр авлагагүй ажилласан байна.</p>	<p>Төсвийн сахилга хариуцлагыг сайжруулан өр, авлага үүсгэхгүй ажиллаж, урьд оныхоо амжилтуудыг ахиулсан байна.</p>	
<p>10.Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль” “ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв санхүүгийн ил тод байдлыг хангуулах. НЗД бөгөөд УБ хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.1.4.1\</p>	<p>10.1 Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалт болон зарцуулалтын мэдээг шилэн дансаар ил тод байлгах.</p>	<p>Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу санхүүгийн сахилга батыг мөрдөж ажиллан хөрөнгө оруулалт болон зарцуулалтын мэдээг шилэн дансаар ил тод байлгах оруулсан мэдээний тоо</p>	<p>Шилэн дансны шалгалтаар “Зөрчилгүй-стандарт” дүгнэлт тус тус гарсан ба ямар нэгэн өр, авлага үүсээгүй байна</p>	<p>Шилэн дансны программд сар, улирал, жилийн эцсийн байдлаар нийт 108 төрлийн мэдээг оруулж зөрчилгүй ажилласан байна.</p>	
<p>11Мэргэшсэн чадварлаг, иргэндээ үйлчилдэг, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн нөлөөг дээшлүүлнэ Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 5.3./</p>	<p>11.1 Байгууллагын албан хаагчдын үйл ажиллагаанд дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах</p>	<p>ЗГ-ын 2020 оны 206-р тогтоолын дагуу шалгалтуудын чанарт ахиц гаргах, дүгнэлтийн мөрөөр тодорхой ажлуудыг зохион байгуулсан байх.</p>	<p>Нэгжүүдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөний дагуу шалгалтуудыг хийж даргын зөвлөлийн хурлаар оруулан танилцуулсан ба шалгалтын дүгнэлт нь тухайн албан хаагчийн хагас</p>	<p>Төлөвлөгөөний дагуу шалгалтууд хийгдсэн мөн ажиллагсадын ажлыг дүгнэх үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж хэрэглэж хэвшсэн байна.</p>	

			болон бүтэн жилийн ажлыг дүгнэх 1 үзүүлэлт болж хэвшсэн	
<p>12 Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлж, иргэдийн оролцоог хангасан, авилгаас ангид үр нөлөөтэй, хариуцлагатай, мэргэшсэн тогтвортой засаглалыг төлөвшүүлнэ. \Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 5 /</p>	<p>12.1 Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх.</p>	<p>ЗГ-ын 2020 оны 206-р тогтоолын дагуу бодлогын баримт бичигт хяналт шинжилгээ үнэлгээ хийн хуваарын дагуу тайлагнасан байх.</p>	<p>Байгууллагын чиглэлтэй холбогдолтой тогтоол захирамж болон бодлогын баримт бичигийн биелэлтэд хяналт шинжилгээ үнэлгээг улирал болон жилийн эцсийн байдлаар хийж холбогдох газарт хүргүүлсэн байна.</p>	<p>Бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөр, дэд хөтөлбөр, эрх зүйн хуулийн үйл ажлын тайланд хяналт шинжилгээ үнэлгээ хийн дээд газарт тогтмол хуваарийн дагуу тайлагнаж ажилласан байна.</p>
<p>13.Нийслэлийн хотын хяналт удирдлагын цогц систем бий болгож, нийслэлийн мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн байдал, аюулгүй байдлыг хангаж, нэг эх сурвалж бүхий мэдээлэлийн сан, өгөгдлийг бий болгосон байна. \Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 5.2 /</p>	<p>13.1 Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлнэ</p>	<p>ҮАГ-ын даргын 2007 оны 59 тоот тушаалаар батлагдсан "Байгууллагын архивын ажлын заавар"-ын дагуу цахим архив үүссэн байх</p>	<p>1995 оноос хойших бүх материал цахимжсан.</p>	<p>Бүх ажилтнуудын файлуудаар 2021 оны цахим архив бий болгосон байна</p>
<p>ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ 2021-2025 ОНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗОРИЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭН ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН СУРЧ БОЛОВСРОХ, АМЬДРАХ УХААНЫ ЧАДВАР ОЛГОХ, УРЛАГ, СПОРТЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ</p>				

<p>1.Бүх нийтийн бүрэн бүтээмжтэй, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ зорилтын хүрээнд \НЗД бөгөөд УБ хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.5/</p>	<p>1.1 Мэргэжил сонголтын аян, зохион байгуулан” мэргэжлийн сургалтад хамрагдуулан ажил мэргэжилтэй болгох сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах</p>	<p>Сургалтын менежер нь сар бүр залуусын 4 төрлийн мэргэжлийн сургалтанд хамрагдсан байдал, багшийн ур чадвар-заах арга зүй, хөтөлбөрийн дагуу явагдаж байгаа эсэх, сэдвийн шалгалт авсан байдал, суралцагч мэргэжлийнхээ дагуу дадлага хийх ажлын байранд зуучлагдсан байдалд үнэлэлт өгч, дүгнэлт гарган цаашид авах арга хэмжээгээ төлөвлөн ажиллах</p>	<p>Шалгалтанд 30 залуус /58,8%/ хамрагдаж онолын тест, дадлага ажлаар шалгалтаа өгч 86%-ийн гүйцэтгэлтэй, 96,6%-ийн амжилттай төгсөн “Чадамжийн гэрчилгээ” авсан байна.</p>	<p>2020 онд явагдах мэргэжлийн сургалтанд 4 Залуучуудын төвд амьдарч байгаа залуусын 80-аас доошгүй хувийг хамруулж, амжилт 90%, чанар 92%-иас доошгүй төгсгөсөн байна. Монгол улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн дагуу осол, гэмтэлгүй, мөн Мэргэжлийн боловсрол, сургалт, Ерөнхий шаардлага MNS 6541:2016 стандартыг мөрдөж ажилласан байна.</p>	
<p>2. Хотын соёлыг төлөвшүүлж түгээн дэлгэрүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулна. \НЗД- бөгөөд УБ хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.6.3\</p>	<p>2.1 Хүүхэд залуус өөрсдийн сонирхлын дагуу дугуйлан, клубүүдэд хамрагдуулж хөгжүүлнэ</p>	<ul style="list-style-type: none"> - Хамрандсан хүүхдийн тоо - Дугуйлангын тоо - Амжилт үзүүлсэн хүүхдийн тоо 	<p>Дотоодын 7 дугуйлан клубүүдэд хамрагдан урлаг, сургалтууд нь тууштай хичээллэн давхардсан тоогоор амжилт гарган 2026 хүүхдийг төлөвшөн мөн шинэ хамруул, 1346 цаг төрлийн гар урлалын хичээллэсэн бүтээлүүдийг гаргасан байна. Байрнаас урлагийн гадуурх дугуйлан, клубуудэд хүүхдийн төвөөс 22 хүүхэд, залуучуудын төвөөс 14 залуус хичээллэж байна</p>	<p>Хүүхэд залуус урлагийн клубүүдэд хамрагдан урлаг, тууштай хичээллэн амжилт гарган төлөвшөн мөн шинэ төрлийн гар урлалын бүтээлүүдийг гаргасан байна. Хүүхэд залуус урлагийн клубүүдэд хамрагдан уралдаан, тэмцээнүүдэд оролцож тодорхой амжилтуудыг үзүүлсэн байна.</p>	

<p>3. Гэр бүлийн гишүүн бүрд чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, гэр бүлийн тогтвортой байдлыг ханган, хүчирхийллийн бүх хэлбэрийг устгана. ИЗД- бөгөөд УБ хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.7.1\</p>	<p>3.1 “Гэр бүлийн өдөрлөг” “Би хариуцлагатай аав, ээж” аян тус бүр зохион байгуулах.</p>	<p>-Үйл ажиллагааны тоо -Хамрагдсан эцэг эхийн тоо - эцэг эхтэй байгуулсан “Хариуцлагын гэрээ”-ний тоо</p>	<p>109 эцэг эхтэй НА, сэтгэлзүйч нар уулзаж хуулийн болон сэтгэлзүй, хүүхдийн хүмүүжлийн талаар зөвлөгөө уулзалт ярилцлагыг хийсэн</p>	<p>Эцэг эхчүүдийн хариуцлагыг дээшлүүлэх гэр бүлийн дулаан уур амьсгалыг бүрдүүлж арга хэмжээнүүдийг зохион байгуулан, эцэг эхтэй байгуулах “Хариуцлагын гэрээ”-г боловсронгуй болгож хэрэглэж хэвшсэн байна.</p>	
<p>4. Гэр бүлийн боловсрол, хөгжил төлөвлөлтийг хийж гэр бүлийн тогтвортой байдлыг хангана. Ийнслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 2.12\</p>	<p>4.1 Хүүхдийн түр хамгаалах байраар үйлчилгээ авсан хүүхдийн эцэг эхийг тогтоох, хамгаалал шаардлагатай хүүхдийг халамжийн хувилбарт үйлчилгээнд хамруулан тэдний гэр бүлтэй ажиллана</p>	<p>Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх” зорилтот ажлыг үргэлжлүүлж боломжтой хүүхдүүдийг гэр бүлд нь нэгтгэх, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 5852:2017 стандартыг мөрдөж ажилласан эсэх</p>	<p>Нийт 19 хүүхэд залуусын гэрт нөхцөл байдлын үнэлгээ хийж, нийт 26 хүүхэд залуусыг ар гэрт нь эргэн нэгтгэсэн байна.</p>	<p>Хамтарсан багийн ажлыг эрчимжүүлж 10-аас доошгүй хүүхдүүдийн ар гэрт Нөхцөл байдлын үнэлгээ хийж тухайн дүүргийн ГБХЗХХ, хорооны хамтарсан багтай хамтран ажиллаж боломжтой хүүхдүүдийг нэгтгэх чиглэл барин ажилласан байна.</p>	
<p>5.Эцэг, эхийн хараа сул, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг эрт илрүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний хяналтыг сайжруулсан байна. Ийнслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 2.14.3/</p>	<p>5.1 Хамгаалах шаардлагатай хүүхэд залуусыг журмын дагуу хүлээн авч үйлчилгээндээ хамруулах</p>	<p>Ийнслэлийн хэмжээнд эцэг эхийн хараа хяналтаас гарсан хагас болон бүтэн өнчин, хамгаалах шаардлагатай 4-17 насны хүүхдийг ийнслэлийн 9 дүүргийн Засаг даргын захирамжаар</p>	<p>6 хүүхдийг захирмжийн дагуу хүлээн авч үйлчилгээнд хамруулан ажилласан.</p>	<p>Хамгаалах шаардлагатай хүүхэд залуучуудыг холбогдох баримт бичгийн дагуу хүлээн авч, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ, асрамж халамж хамгааллын үйлчилгээнд хамруулан нийгэмшүүлэн</p>	

		хүлээн авах, хүүхдийн асрамж халамжийн төвд амьдарч байгаад 18 насанд хүрсэн, эцэг эх харгалзан дэмжигчгүй, гэр оронгүй, ажил мэргэжилгүй, төрөөс зайлшгүй анхаарах шаардлагатай 18-20 насны залуусыг хүлээн авах		төлөвшүүлж, мэргэжил эзэмшүүлэн ажлын байранд зуучилж, бие даасан амьдрал бэлтгэсэн байна.	
6.Хүүхэд бүрийг төлбөргүй, тэгш чанартай бага болон суурь боловсрол эзэмших нөхцөлөөр хангана. /НЗД бөгөөд УБ хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.1/	6.1 Хүүхэдийг ЕБС-д суралцуулах хичээлийн хоцрогдлыг арилгах	Хүүхдүүдийн унших, бичих, бодох, хүрд цээжилсэн үзүүлэлт дээшилсэн байна	ЕБС-д 3 хүүхэд /42,8%/ шилжүүлсэн бөгөөд минутын уншлага 78,6%, цээж бичиг 65,2% буюу нийлбэр нь 71,8% байна..	ЕБС-т шилжүүлсэн хүүхдийн тоо 7, унших, бичих, бодох, хүрд цээжилсэн үзүүлэлт 30% дээшилсэн байна	
7.Мэргэжлийн байгууллагатай хамтран суралцагчдыг зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ. /Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 2.4.3	7.1 Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах.	Авто замын осол, гэмтлээс хэрхэн урьдчилах сэргийлэх талаарх 10 доошгүй үйл ажиллагаа зохион байгуулсан эсэх, Зам тээврийн осол гэмтлээс хүүхдийн хамгаалсан байх	Цогцолборын нийт хүүхдүүдийг 4 үйл ажиллагаанд хамруулан ослоос урьчилан сэргийлсэн байна.	Урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлуудыг төрийн болон ТББ-уудтай хамтран 10-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж Зам тээврийн осол гэмтлээс хүүхдийн 100% хамгаалсан байна.	
8.Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах , тандах, эмчлэх үйл ажиллагааг	8.1 “Эрүүл залуус” аяны хүрээнд Өсвөр үе, залуучуудыг БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх болон	Сургалт, мэдээллийн жил бүр 5-аас доошгүй арга хэмжээг зохион	Нийт 10 сургалтын арга хэмжээнүүдийг /100%/ зохион	Бүх ажиллагсад болон хүүхэд залуучуудыг 100% урьдчилан сэргийлэх үзлэгт	

<p>сайжруулан өвчлөлийг бууруулна. НЗД- бөгөөд УБ хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.1</p>	<p>бусад эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулж урьдчилан сэргийлэх талаарх сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан байна</p>	<p>байгуулан залуусыг 100% шинжилгээнд хамрагдсан болон эмчлүүлсэн залуусын тоо</p>	<p>байгуулж давхардсан тоогоор 186 хүүхэд залуусыг хамруулсан байна. Урьдчилан сэргийлэх үзлэг болон эмчилгээнд 8 хүүхэд залуусыг хамруулснаас гадна охиудаас сар бүр жирэмсний тэст авсан байна</p>	<p>харуулсан байх, үзлэгийн дүнгийн дагуу зохих арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулсан байна.</p>	
<p>9. Залуучуудын хөгжлийг төвийг байгуулан өсвөр үе залуучуудыг сөрөг зан үйл, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх, ажлыг шат дараатай зохион байгуулах. НЗД- бөгөөд УБ хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.7.3.1\</p>	<p>9.1 “Амьдрах ухааны чадвар олгох” 12 модуль сургалтыг үе шаттай зохион байгуулах</p>	<p>Өсвөр үе, залуучуудыг 100% амьдрах ухааны чадвар олгох сургалтад хамруулсан эсэх</p>	<p>Амьдрах ухааны боловсрол олгох сургалт орж байгаагүй</p>	<p>Өсвөр үе залуучуудыг “Амьдрах ухааны чадвар олгох” 12 модуль сургалтад 100% хамруулан хүн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн бүхий л харилцаанд өөрийгөө идэвхжүүлэн, амьдралынхаа туршид нийгмийн хөгжлөөс хоцрохгүй байх, бие бялдар, оюун санаагаа байнга хөгжүүлэх ур чадваруудыг эзэмших, түүнийгээ тасралтгүй хөгжүүлэхэд шаардагдах мэдлэг чадварын цогцыг олгосон байна.</p>	
	<p>9.2 “Нийслэлийн иргэний дагаж мөрдөх 10 зөв дадлыг хэвшүүлэн залуучуудын нийгмийн</p>	<p>-Залуучуудын зөвлөлийн үйл ажиллагаа идэвхжсэн байна.</p>	<p>10 зөв дадлыг хэвшүүлэхэд чиглэсэн нийт 37 сургалт</p>	<p>Залуучуудын зөвлөл идэвхжин бусаддаа зөв үлгэр дурайлал болох нөлөөллийн арга</p>	

	идэвхи , оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлж, эерэг бодол хандлагатай бүтээлч иргэн болгон төлөвшүүлэх аян, сурталчилгаа нөлөөллийн ажлуудыг зохион байгуулна.	-Үйл ажиллагааны тоо -Хандлага өөрчлөгдсөн залуусын тоо	нөлөөллийн ажлыг зохион байгуулж давхардсан тоогоор 972 залуус хамрагдсан байна	хэмжээ зохион байгуулан Нийслэлийн дагаж мөрдөх 10 зөв дадлыг нийт залуучуудад эзэмшүүлсэн байна.	
10. Гэр бүлийн гишүүн бүрд чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, гэр бүлийн тогтвортой байдлыг ханган, хүчирхийллийн бүх хэлбэрийг устгана. НЗД- бөгөөд УБ хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.7.2/	10.1 Хүүхдийн хамгааллын "Able" программд эрсдэлд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн мэдээлэлд хяналт тавих, Эрсдэл өндөр хүүхдийг "Хүүхдийн эрсдэлийн даатгал"-ын үйлчилгээнд хамруулна.	Шинээр ирсэн бүх хүүхдүүд уг программд бүртгэгдсэн бөгөөд "Хүүхдийн эрсдэлийн даатгал"-ын үйлчилгээнд хамрагдсан байна.	Хүүхдийн хамгааллын "Able" программд нийт 74 хүүхдийн мэдээлэл оруулан бүртгэлжүүлж хяналт тавин, Зуслан гарах үед хүүхдүүдийг "Бодь даатгал"-ийн гэнэтийн ослын даатгалд хамруулсан болно	Шинээр бүх хүүхдүүдийг уг даатгалд зуны амралтын хугацаанд 100% "Гэнэтийн ослын даатгал"-д тус тус хамруулна	
ГУРАВ. ХҮҮХДИЙН ЭРХИЙН, ХҮҮХДИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ БОЛОН ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИУД БОЛОН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ БАГЦ ХУУЛИЙН ХҮРЭЭНД ХАЛАМЖ, ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫН ОНОВЧТОЙ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДАД ТҮРГЭН ШУУРХАЙ ХҮРГЭХ.					
3.Хүүхэд оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах эрхтэй /Хүүхдийн эрхийн тухай Монгол улсын хуулийн 6.1.3. дахь заалт/	3.1 " Амжилтын гараа" уралдааныг зохион байгуулах	Төгсөх ангийн сурагчдыг амжилттай оролцуулсан эсэх	2020 оны элсэлтийн Ерөнхий шалгалтаар цогцолборын 1 хүүхэд 800 оноо авч амжилт үзүүлсэн.	Суралцагчдын сурлагын амжилт чанарыг ахиулах, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх, шалгалт өгөх сэтгэл зүйн бэлтгэл хангах, төстийн шалгалтын найдвартай байдалд хяналт тавих, хүүхэд бүрд сурч, хөгжих тэгш боломжийг бүрдүүлэн,	

				боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулсан байна.
2. Орлогоо нэмэгдүүлэх хүсэлтэй оюутан, залуучууд хамрагдаж болох ажлын байрыг бий болгоход гадаад орны туршлага, “оюутны цагийн ажил”, “ажлын уян хатан цаг”-ийг нэвтрүүлэх талаар ажил олгогчидтой хамтран ажиллах; /Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 5.3.8. дахь заалт/	2.1 Залуучуудыг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, тогтвортой ажлын байранд холбон зуучлах үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах.	-Жил улирал бүр ажилд зуучлагдсан залуусын тоо -Тогтвортой ажилласан залуучуудын тоо -Хуритмал үүсгэсэн эсэх	Давхардсан тоогоор нийт 75 залуус хөдөлмөр эрхэлсэн байна.	Хөдөлмөрийн төв бирж, ТББ-ууд, хувь хүмүүстэй холбогдон залуучуудад тохирох сул, чөлөөтэй ажлын байрны захиалгыг авч танилцуулснаар 2021 онд нийт залуусын 80-аас доошгүй хувь нь цагийн, түр, байнгын ажилд зуучлагдан 13,6 сая ₮ дүнтэй цалин, орлоготой болсон байна.
3. Зорилтот бүлгийн залуучуудад чиглэсэн биеийн тамир, спорт, сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх; /Залуучуудын хөгжлийг дэмжих тухай Монгол улсын хуулийн 10.1.5. дахь заалт/	3.1. Сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч эрсдэлд нөхцөлд байгаа хүүхэд залуучуудад сэтгэл заслын үйлчилгээг өгч эрсдэлийг бууруулсан байна	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн төвшин урд оныхоос 1 дахин ахисан эсэх, хүүхэд, залуусын нийгэмших, төлөвших байдалд ахиц гарах, тэдний оролцоог дээшлүүлэх	Нийт 5 төрлийн судалгаа авахад хэрэглэгч болон хамтрагч байгууллагын “сэтгэл ханамж 82,5%”-тай байна	Судалгаа авч дүгнэлтийн дагуу төлөвлөгөө гарган Хүүхэд, есвөр үеийнхэнд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж үзүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх тулгамдаж байгаа асуудлыг тодруулан сэтгэл зүйн амар тайван байдлыг бий болгон тодорхой үр дүнд хүрсэн байна.
4. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төрийн байгууллага эсхүл тухайн	4.1 Мэргэжлийн байгууллагуудтай хамтран албан хаагч болон	-Арга хэмжээ зохион байгуулж, хамрагдагсадын тоо, чанарт ахиц гаргах	БЗД-ийн Цагдаагийн 3-р хэлтэс болон бусад ТББ-уудтай	6 удаагийн сургалтыг ажиллагсад, хүүхэд, залуус болон тэдний эцэг эхийг хамруулан

<p>чиглэлээр мэргэшсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлнэ. /Хүүхэд хамгааллын тухай Монгол улсын хуулийн 10.2 дахь заалт/</p>	<p>цогцолборын хүүхэд залуучуудад эрх зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах</p>	<p>- Хүүхдийн эрхийг хамгаалж хууль ёсний төлөөлөгчөөр ажилласан байх</p>	<p>хамтран 4 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 70 гаруй хүүхэд, залуусыг хамруулсан байна. ганцаарчилсан уулзалт, зөвлөгөөг давхардсан тоогоор 25 удаа 12, хүүхэд залууст үзүүлсэн байна</p>	<p>зохион байгуулсан мөн зөрчил гаргасан хүүхэд залууст тухай бүрт нь ганцаарчилсан зөвлөгөө өгч хуль ёсний төлөөлөгчөөр ажилласан байна</p>	
<p>5. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй хангах; Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай Монгол Улсын хууль 7.1.11 заалт</p>	<p>5.1 Даргын зөвлөл дээд газраас бичгийн дагуу шуурхай хуралдаж арга хэмжээ авч ажилласан</p>	<p>Тогтмол ариутгал цэвэрлэгээ болон ээлжийн ажлыг цаг үетэй холбогдуулан зохицуулалт хийх -Дархлаажуулалтын үйл ажиллагаа хийх</p>	<p>Цар тахлыг лотооддоо алдалгүй урьдчилан сэргийлж ажилласан байна.</p>	<p>Албан хаагч болон хүүхэд залуучуудыг цар тахал өвчнөөс урьдчилан сэргийлэн тогтмол ариутгал цэвэрлэгээ болон ээлжийн ажлыг цаг үетэй холбогдуулан зохицуулалт хийж цар тахал өвчлөл гаргахгүй байх тал дээр анхаарч хяналт тавьж ажиллана.</p>	
<p>6.Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгоно.</p>	<p>6.1Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн мэдээллийг үнэн зөв хүргэх</p>	<p>Вэб сайтын хөтлөлт, шинэчлэлийг тогтмол хийж байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан эсэх</p>	<p>100%</p>	<p>Цаг үеийн холбогдолтой байгууллагын үйл ажиллагааг цахим хуудсанд байршуулан мэдээ мэдээллийг 100% ил тод болгон иргэдэд цаг алдалгүй шуурхай хүргэсэн байна.</p>	

/ НЗД бөгөөд УБ хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.1/					
<p>7.Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллаганы ил тод, нээлттэй байдлыг хангана.</p> <p>НЗД бөгөөд УБ хотын захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.2.2 /</p>	<p>7.1 Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, соён үйл ажиллагааг зохион байгуулах</p>	<p>Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллагын үйл ажиллаанд тохируулан зохион байгуулан авлигын эсрэг хуулийг сурталчилсан эсэх</p> <p>-Арга хэмжээний тоо</p>	<p>Төлөвлөгөөний дагуу нийт 4 төрлийн нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулан авлигын үйл ажиллагааг ил тод мэдээллийн салбарт байршуулан ажилласан байна.</p>	<p>АТГ-ын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллан албан хаагч болон хүүхэд залуучуудад авилгын эсрэг хууль болон олон талт сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулан үр дүнг тайлагнасан байна.</p>	